АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Архангай аймгийн Хотонт сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: АРА-2026/92/НА-СТА-ТШЗ**


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.open.audit.mn<br>Архангай аймаг<br>2026 он | Дарга,Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа<br>Утас:7033-3141<br>Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn<br>Аудитын менежер Д.Нэргүйбаатар<br>Утас: 7033-2860<br>Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn<br>Аудитыг гүйцэтгэсэн: Гроут финанс Аудит ХХК-ийн<br>Гүйцэтгэх захирал Б.Бямбадорж<br>Утас:7772-1628<br>Цахим хаяг: Byambadorj@grownance.mn |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2026.02.25 № 91

танай ______________-ны №______________-т

ХОТОНТ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Ч.БАТБААТАР ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Хотонт сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Аудитын гол асуудал

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх “Ерөнхий боловсрол” хөтөлбөрийн хүрээнд үндсэн үйл ажиллагааны 15 арга хэмжээг санхүүжүүлэхээр 3,561,632.1 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрдүүлж, гүйцэтгэлээр 3,390,980.4 мянган төгрөг зарцуулсан байна.

### Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 5 үндсэн зорилтын хүрээнд 106 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажилласан байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т.БАЙГАЛМАА

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* ( төгрөгөөр)

| Дансны код | Балансын зүйл | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **394,329,338.89** | **228,856,491.43** |
| 31 | **МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ** | **238,876,409.13** | **39,574,352.47** |
| 312 | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | **238,876,409.13** | **39,574,352.47** |
| 3121 | **Төгрөг** | **238,876,409.13** | **39,574,352.47** |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 238,876,409.13 | 39,574,352.47 |
| **33** | **АВЛАГА** | **-** | **-** |
| 35 | **БАРАА МАТЕРИАЛ** | **155,452,929.76** | **189,282,138.96** |
| **351** | **Түүхий эд материал** | **25,959,949.25** | **30,207,858.45** |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 16,792,399.25 | 29,894,158.45 |
| 35130 | Эм боох материал | 9,167,550.00 | 313,700.00 |
| **353** | **Бэлэн бүтээгдэхүүн** | **1,071,000.00** | **1,174,800.00** |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 1,071,000.00 | 1,174,800.00 |
| 354 | **Хангамжийн материал** | **128,421,980.51** | **157,899,480.51** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 14,215,420.00 | 14,215,420.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 99,265,870.51 | 142,097,370.51 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 2,287,500.00 | 700,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 12,653,190.00 | 886,690.00 |
| 2 | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,825,145,816.06** | **2,516,987,297.29** |
| 39 | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **1,825,145,816.06** | **2,516,987,297.29** |
| 392 | **Биет хөрөнгө** | **1,771,795,816.06** | **2,462,437,297.29** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,936,014,602.69 | 2,474,751,202.69 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (509,703,804.40) | (589,470,451.36) |
| 39203 | Авто тээврийн хэрэгсэл | 10,500,000.00 | 10,500,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (5,512,500.00) | (6,562,500.00) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 208,279,278.60 | 329,783,598.60 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (39,058,130.69) | (46,218,121.78) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 150,021,570.29 | 285,332,337.85 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (18,387,756.39) | (45,321,324.67) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | - | 10,000,000.00 |
| 39217 | Ном | 39,642,555.96 | 39,642,555.96 |
| 393 | **Биет бус хөрөнгө** | **53,350,000.00** | **54,550,000.00** |
| 39301 | Програм хангамж | - | 1,200,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 53,350,000.00 | 53,350,000.00 |
| 3 | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **2,219,475,154.95** | **2,745,843,788.72** |
| 4 | **НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН** | **-** | **23,083,670.00** |
| 41 | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **23,083,670.00** |
| 413 | **Өглөг** | **-** | **23,083,670.00** |
| 4136 | **Бусад өглөг** | **-** | **23,083,670.00** |
| 41361 | **Байгууллагад төлөх өглөг** | - | 23,083,670.00 |
| 5 | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **2,219,475,154.95** | **2,722,760,118.72** |
| 51 | **Засгийн газрын хувь оролцоо** | **2,219,475,154.95** | **2,722,760,118.72** |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,907,505,089.32 | 1,907,505,089.32 |
| 51101 | Өмч: - төрийн | 1,907,505,089.32 | 1,907,505,089.32 |
| 512 | **Хуримтлагдсан үр дүн** | **(343,484,578.31)** | **159,800,385.46** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (343,484,578.31) | (343,484,578.31) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 503,284,963.77 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 655,454,643.94 | 655,454,643.94 |
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **2,219,475,154.95** | **2,745,843,788.72** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* ( төгрөгөөр)

| Дансны код | Балансын зүйл | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,894,932,849.25** | **4,055,010,933.85** |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **51,547,649.25** | **874,477,533.85** |
| 120 | **Нийтлэг татварын бус орлого** | **51,547,649.25** | **874,477,533.85** |
| **120004** | **Төсөвт байгууллагын өөрийн орлого** | **11,395,200.00** | **23,319,900.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 11,030,200.00 | 20,644,900.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 365,000.00 | - |
| 120009 | Бусад орлого | - | 2,675,000.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-үндсэн хөрөнгө | 23,360,050.00 | 804,885,874.65 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал | 16,792,399.25 | 46,271,759.20 |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,843,385,200.00** | **3,180,533,400.00** |
| 1310 | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **2,746,740,800.00** | **3,063,553,600.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 2,746,740,800.00 | 3,063,553,600.00 |
| 1311 | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **-** | **-** |
| 1320 | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **96,644,400.00** | **116,979,800.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 96,644,400.00 | 116,979,800.00 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | **-** | **-** |
| 2 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)** | **2,743,800,380.09** | **3,551,725,970.08** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,743,800,380.09** | **3,551,725,970.08** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,667,540,840.09** | **3,414,642,550.08** |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,970,800,471.00** | **2,432,369,564.12** |
| 210101 | Цалин | 1,232,514,315.00 | 1,403,303,648.29 |
| 210102 | Нэмэгдэл цалин | 630,112,741.00 | 871,171,471.83 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 9,020,000.00 |
| 210104 | Урамшуулал | 108,173,415.00 | 148,874,444.00 |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **245,821,534.00** | **305,526,400.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 168,567,532.98 | 207,757,900.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 20,529,553.73 | 24,442,000.00 |
| 210203 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 10,143,691.38 | 12,221,300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 10,105,739.30 | 12,221,300.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 36,475,016.61 | 48,883,900.00 |
| 2103 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **99,392,852.61** | **115,928,300.00** |
| 210301 | Гэрэл цахилгааны зардал | 25,530,228.61 | 45,402,243.57 |
| 210302 | Түлш, халаалтын зардал | 73,562,624.00 | 70,226,056.43 |
| 210303 | Цэвэр, бохир усны зардал | 300,000.00 | 300,000.00 |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | **-** | **-** |
| 2105 | **Нормативт зардал** | **209,481,200.00** | **283,127,140.00** |
| 210502 | Хоол, хүнс | 209,481,200.00 | 283,127,140.00 |
| 2106 | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **671.39** | **-** |
| 210604 | Урсгал засвар | 671.39 | - |
| 2107 | **Томилолт, зочны зардал** | **-** | **-** |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж** | **20,183,108.73** | **38,292,080.54** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 50,000.00 | 8,194,900.00 |
| 210806 | Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс | 20,133,108.73 | 30,097,180.54 |
| 2109 | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **121,861,002.36** | **239,399,065.42** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 62,305,101.00 | 81,304,422.00 |
| 210902 | Хичээл үйлвэрлэлийн дадлага хийх | 19,163,950.00 | 17,474,250.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 40,391,951.36 | 140,620,393.42 |
| 213 | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **76,259,540.00** | **137,083,420.00** |
| 2132 | **Бусад урсгал шилжүүлэг** | **76,259,540.00** | **127,583,420.00** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 76,259,540.00 | 109,498,730.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 18,084,690.00 |
| 2133 | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **-** | **-** |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **-** | **9,500,000.00** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 9,500,000.00 |
| 3 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **151,132,469.16** | **503,284,963.77** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **8,268,004.55** | **-** |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | **8,268,004.55** | |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145- 225)** | **(8,268,004.55)** | **-** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **142,864,464.61** | **503,284,963.77** |

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* ( төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны дүн | Тайлант жилийн дүн |
|---|---|---|---|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | 2,854,780,400.00 | 3,201,178,300.00 |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | 11,395,200.00 | 20,644,900.00 |
| 120 | **Нийтлэг татварын бус орлого** | 11,395,200.00 | 20,644,900.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 11,395,200.00 | 20,644,900.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 11,030,200.00 | - |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 365,000.00 | - |
| 120009 | Бусад орлого | - | - |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | 2,843,385,200.00 | 3,180,533,400.00 |
| 1310 | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 2,746,740,800.00 | 3,063,553,600.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 2,746,740,800.00 | 3,063,553,600.00 |
| 1320 | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 96,644,400.00 | 116,979,800.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 96,644,400.00 | 116,979,800.00 |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | 2,729,708,128.73 | 3,375,579,356.66 |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 2,729,708,128.73 | 3,375,579,356.66 |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2,652,722,638.73 | 3,245,254,956.66 |
| 2101 | **Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,951,116,105.00 | 2,432,369,564.12 |
| 210101 | Үндсэн цалин | 1,192,267,520.00 | 1,403,303,648.29 |
| 210102 | Нэмэгдэл | 651,411,117.00 | 871,171,471.83 |
| 210103 | Унаа хоолны Хөнгөлөлт | - | 9,020,000.00 |
| 210104 | Урамшуулал | 107,437,468.00 | 148,874,444.00 |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 265,505,900.00 | 305,526,400.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 180,544,100.00 | 207,757,900.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 21,240,400.00 | 24,442,000.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 10,620,200.00 | 12,221,300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 10,620,200.00 | 12,221,300.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 42,481,000.00 | 48,883,900.00 |
| 2103 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 94,085,400.00 | 114,340,800.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 25,530,228.61 | 45,402,243.57 |
| 210302 | Түлш, халаалт | 68,254,500.00 | 68,638,556.43 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 300,671.39 | 300,000.00 |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | - | - |

| | | | |
|---|---|---|---|
| 2105 | **Нормативт зардал** | 219,630,300.00 | 257,149,200.00 |
| 210502 | Хоол, хүнс | 219,630,300.00 | 257,149,200.00 |
| 2106 | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 5,139,000.00 | 5,219,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,139,000.00 | 5,219,000.00 |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 34,278,548.73 | 43,342,980.54 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 0.00 | 8,194,900.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 34,278,548.73 | 35,148,080.54 |
| 2109 | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 82,967,385.00 | 87,307,012.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 71,383,685.00 | 72,566,012.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 11,583,700.00 | 14,741,000.00 |
| 213 | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 76,985,490.00 | 130,324,400.00 |
| 2132 | **Бусад урсгал шилжүүлэг** | 76,985,490.00 | 120,824,400.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 76,985,490.00 | 100,730,300.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 20,094,100.00 |
| 2133 | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | - | 9,500,000.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг -Орон нутгийн төсөв | - | 9,500,000.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 125,072,271.27 | (174,401,056.66) |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | - | 24,901,000.00 |
| | Дотоод эх үүсвэрээр | - | 24,901,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | - | 24,901,000.00 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | - | (24,901,000.00) |
| 8 | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 125,072,271.27 | (199,302,056.66) |
| 9 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 148,894,537.86 | 238,876,409.13 |
| 10 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 238,876,409.13 | 39,574,352.47 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* ( төгрөгөөр)

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл** | **1,907,505,089.32** | **655,454,643.94** | **(486,349,042.92)** | **2,076,610,690.34** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,907,505,089.32** | **655,454,643.94** | **(486,349,042.92)** | **2,076,610,690.34** |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 142,864,464.61 | 142,864,464.61 |
| **2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл** | **1,907,505,089.32** | **655,454,643.94** | **(343,484,578.31)** | **2,219,475,154.95** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,907,505,089.32** | **655,454,643.94** | **(343,484,578.31)** | **2,219,475,154.95** |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 503,284,963.77 | 503,284,963.77 |
| **2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл** | **1,907,505,089.32** | **655,454,643.94** | **159,800,385.46** | **2,722,760,118.72** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* ( төгрөгөөр )

| Эдийн засгийн ангилал | Дансны код | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | | **3,557,090,600.00** | **3,390,980,356.66** | **166,110,243.34** | **95.33** |
| **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **3,557,090,600.00** | **3,390,980,356.66** | **166,110,243.34** | **95.33** |
| **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | **3,417,526,400.00** | **3,270,155,956.66** | **147,370,443.34** | **95.69** |
| **Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил** | | **2,536,795,800.00** | **2,432,369,564.12** | **104,426,235.88** | **95.88** |
| Үндсэн цалин | 210101 | 1,608,654,900.00 | 1,403,303,648.29 | 205,351,251.71 | 87.23 |
| Нэмэгдэл | 210102 | 848,256,000.00 | 871,171,471.83 | (22,915,471.83) | 102.70 |
| Унаа хоолны Хөнгөлөлт | 210103 | - | 9,020,000.00 | (9,020,000.00) | - |
| Урамшуулал | 210104 | 79,884,900.00 | 148,874,444.00 | (68,989,544.00) | 186.36 |
| **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | | **317,630,800.00** | **305,526,400.00** | **12,104,400.00** | **96.19** |
| Тэтгэврийн даатгал | 210201 | 215,989,000.00 | 207,757,900.00 | 8,231,100.00 | 96.19 |
| Тэтгэмжийн даатгал | 210202 | 25,410,500.00 | 24,442,000.00 | 968,500.00 | 96.19 |
| ҮОМШӨ-ний даатгал | 210203 | 12,705,200.00 | 12,221,300.00 | 483,900.00 | 96.19 |
| Ажилгүйдлийн даатгал | 210204 | 12,705,200.00 | 12,221,300.00 | 483,900.00 | 96.19 |
| Эрүүл мэндийн даатгал | 210205 | 50,820,900.00 | 48,883,900.00 | 1,937,000.00 | 96.19 |
| **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | | **114,340,800.00** | **114,340,800.00** | **(0.00)** | **100.00** |
| Гэрэл, цахилгаан | 210301 | 33,315,100.00 | 45,402,243.57 | (12,087,143.57) | 136.28 |
| Түлш, халаалт | 210302 | 74,425,700.00 | 68,638,556.43 | 5,787,143.57 | 92.22 |
| Цэвэр, бохир ус | 210303 | 6,600,000.00 | 300,000.00 | 6,300,000.00 | 4.55 |
| **Хангамж, бараа материалын зардал** | | **-** | **-** | **-** | **-** |
| **Норматив зардал** | | **287,149,200.00** | **257,149,200.00** | **30,000,000.00** | **89.55** |
| Хоол, хүнс | 2E+05 | 287,149,200.00 | 257,149,200.00 | 30,000,000.00 | 89.55 |
| **Эд хогшил, урсгал засварын зардал** | | **5,219,000.00** | **5,219,000.00** | **-** | **100.00** |
| Урсгал засвар | 210604 | 5,219,000.00 | 5,219,000.00 | - | 100.00 |
| **Томилолт, зочны зардал** | | - | **-** | **-** | **-** |
| **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | | **43,956,900.00** | **43,342,980.54** | **613,919.46** | **98.60** |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 210801 | 8,194,900.00 | 8,194,900.00 | - | 100.00 |
| Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 210806 | 35,762,000.00 | 35,148,080.54 | 613,919.46 | 98.28 |
| **Бараа үйлчилгээний бусад зардал** | | **112,433,900.00** | **112,208,012.00** | **225,888.00** | **99.80** |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 210901 | 97,692,900.00 | 97,467,012.00 | 225,888.00 | 99.77 |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага | 210902 | 14,741,000.00 | 14,741,000.00 | - | 100.00 |
| **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | | **139,564,200.00** | **120,824,400.00** | **18,739,800.00** | **86.57** |
| **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | | **-** | **-** | **-** | - |
| **Бусад урсгал шилжүүлэг** | | **139,564,200.00** | **120,824,400.00** | **18,739,800.00** | **86.57** |
| Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 213205 | 119,470,100.00 | 100,730,300.00 | 18,739,800.00 | 84.31 |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 213209 | 20,094,100.00 | 20,094,100.00 | - | 100.00 |
| **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | | **3,557,090,600.00** | **3,191,678,300.00** | **377,862,300.00** | **89.73** |
| **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | | **3,429,335,900.00** | **3,063,553,600.00** | **365,782,300.00** | **89.33** |
| Улсын төсвөөс санхүүжих | 131001 | 3,190,850,500.00 | 3,063,553,600.00 | 127,296,900.00 | 96.01 |
| Оны эхний үлдэгдлээс санхүүжих | 1E+05 | 238,485,400.00 | - | 238,485,400.00 | - |
| **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | | **119,559,800.00** | **107,479,800.00** | **12,080,000.00** | **89.90** |
| Орон нутгийн төсвөөс | 1E+05 | 119,559,800.00 | 107,479,800.00 | 12,080,000.00 | 89.90 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | | **8,194,900.00** | **20,644,900.00** | **-** | **251.92** |
| Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1E+06 | 8,194,900.00 | 20,644,900.00 | (12,450,000.00) | 251.92 |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | **238,876,409.13** | **238,876,409.13** | **-** | **100.00** |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | **238,876,409.13** | **39,574,352.47** | **211,752,056.66** | **16.57** |
| ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | | | | | |
| БАЙГУУЛЛАГЫН ТОО | | 1 | 1 | - | 100.0 |
| Төсвийн байгууллага | | 1 | 1 | - | 100.0 |
| АЖИЛЛАГСАДЫН ТОО | | 83 | 83 | - | 100.0 |
| Удирдах ажилтан | | 3 | 3 | - | 100.0 |
| Гүйцэтгэх ажилтан | | 49 | 49 | - | 100.0 |
| Үйлчлэх ажилтан | | 31 | 31 | - | 100.0 |
| СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР) | | 715 | 714 | 1 | 99.9 |
| ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД | | 715 | 714 | 1 | 99.9 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 47,431.6 мянган төгрөгийн алдаа[1] илэрснээс аудитын явцад 2,009.4 мянган төгрөгийн алдааг залруулж, 45,422.2 мянган төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа:

- Байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний урамшуулал 20,094.1 мянган төгрөгөөс хувь хүний орлогын албан татвар 2,009.4 мянган төгрөгийг суутган төлсөн болович "Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого, шууд бус орлогод ногдуулан суутгасан албан татварын тайлан" ТТ11-ээр тайлагнаагүй байсныг залруулсан.

Залруулаагүй алдаа:

- Санхүүгийн тайлан дахь үндсэн хөрөнгийн дүн 45,422.2 мянган төгрөгөөр илүү илэрхийлэгдсэн. Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийн эхний үлдэгдлийн дүн 72,561.5 мянган төгрөгийн зөрүүтэй байсан бол эцсийн үлдэгдлийн зөрүү дүн 45,422.2 мянган төгрөгийн мянган төгрөг байна. Тайлант оны элэгдлийн зардлын дүн 27,339.3 мянган төгрөгөөр илүү байгаа нь дээрх зөрүүг алдаатай залруулсантай холбоотой.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална:", 5.1.4 "үнэн зөв байх" гэснийг хэрэгжүүлэн ажиллах, алдааг залруулан тайлагнах зөвлөмжийг өгсөн

<u>*Шийдвэрлэсэн нь*</u>: Холбогдох хуулийг хэрэгжүүлэн ажиллах, алдааг залруулан тайлагнах зөвлөмжийг өгсөн.

Аудитаар залруулаагүй 6,330.9 мянган төгрөгийн зөрчил[2] илэрч 430.7 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 5,900.2 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага тус тус хүргүүллээ.

Аудитаар залруулагдаагүй 4 зөрчилтэй асуудлын материаллаг алдаа зөрчил нь 6,330.9 мянган төгрөг, залруулагдаагүй алдаа 45,422.2 мянган төгрөг бөгөөд гүйцэтгэлийн

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.
[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

материаллаг байдлын дүн 37,469.6 мянган төгрөгөөс их боловч залруулагдаагүй алдаа нь дангаараа “өргөн тархаагүй байх” тул **Өөрчлөлтгүй дүгнэлт** өглөө.

**3.1 Төлбөрийн акт**

3.1.1. Нэр бүхий 2 ажилтанд ажлаагүй байсан хугацаанд нь 345.7 мянган төгрөгийн цалин тооцон олгожээ. Энэ нь цагийн бүртгэл буруу, цагийн бүртгэлээс зөрүүтэйгээр цалин бодсонтой холбоотой байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" мөн 'Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 "Төрийн албан хаагч дараахь нийтлэг үүрэг хүлээнэ": 37.1.6 "харьяа дээд шатны албан тушаалтны зөвхөн хуульд нийцсэн шийдвэрийг биелүүлэх" гэсэн заалтыг зөрчиж байна.

*Шийдвэрлэсэн нь*: Төсөвт буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

3.1.2. Нэр бүхий 6 ажилтанд хоолны хөнгөлөлт 85.0 мянган төгрөгийг илүү тооцон олгосон.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.3 "гүйцэтгэсэн ажил үүрэгтээ тохирсон цалин хөлс авах" мөн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэсэн заалтыг зөрчиж байна.

*Шийдвэрлэсэн нь*: Төсөвт буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

**3.2 Албан шаардлага**

3.2.1. Багш ажилтнуудын гүйцэтгэлийн үнэлгээний урамшууллыг олгохдоо зөвхөн "Хувь хүний орлогын албан татвар" 10 хувь 2,009.4 мянган төгрөг суутган 18,084.7 мянган төгрөгийг 85 ажилтанд олгохдоо суутган буюу ногдуулан төлөх 4,776.2 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг суутган тайлагнаагүй байна.

Энэ нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 19 дугаар зүйлийн 19.1 “Даатгуулагч, ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл ногдох орлогын бүрэлдэхүүнд дараах цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг хамааруулна”: 19.1.1 "Хөдөлмөрийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.5 дахь хэсэг, 101 дүгээр зүйлийн 101.1 дэх хэсэг, 111, 112, 113, 114, 115, 116, 117 дугаар зүйлд тус тус заасан цалин хөлс, олговор" гэсэн заалтыг зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь*: Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

3.2.2 ХХОАТ-ын тухай хуулийн 23.1-т заасан хөнгөлөлтийг 40 ажилтанд 474.0 мянган төгрөгөөр илүү эдлүүлснээс татварыг мөн дүнгээр дутуу, 26 ажилтанд 650.0 мянган төгрөгөөр дутуу эдлүүлснээс татварыг мөн дүнгээр илүү тайлагнажээ.

Энэ нь Татварын ерөнхий газрын даргын 2019 оны А/261 дүгээр тушаалын хавсралт "Хувь хүний орлогыг албан татвараас чөлөөлөх, албан татварын хөнгөлөлт эдлүүлэх журам"-ын 4.4.1 "Тухайн тайлант жилийн 12 сард бүрэн тухайн байгууллагад харьяалагдаж ажилласан ажилтанд Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23.1-д заасан хөнгөлөгдөх татварын хэмжээг мөн хуулийн 27.1-д заасны дагуу жилийн эцэст өссөн дүнгээр тооцож, зөрүүг залруулж тайлагнана", 4.4.2 "Тайлант жилийн 12 сарын турш тухайн байгууллагад харьяалагдаж ажиллаагүй ажилтныг Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23.1-д заасан хөнгөлөгдөх татварын хэмжээг суутгагч өссөн дүнгээр тооцох, зөрүүг залруулах үүрэг хүлээхгүй" гэсэн заалтыг зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь*: Татварын ерөнхий газрын даргын 2019 оны А/261 дүгээр тушаалын хавсралт "Хувь хүний орлогыг албан татвараас чөлөөлөх, албан татварын

хөнгөлөлт эдлүүлэх журам"-ын хэрэгжилтийг ханган ажиллах, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл** *(мянган төгрөгөөр)*

| № | Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Үндсэн хөрөнгийн алдаатай илэрхийлэл | 1 | 45,422.2 | | | 1 | 45,422.2 | | | 1 | 45,422.2 | 1 | 45,422.2 |
| 2 | Татварыг дутуу тайлагнасан | 1 | 2,009.4 | 1 | 2,009.4 | | | 1 | 2,009.4 | | | | |
| | **Нийт дүн** | **2** | **47,431.6** | **1** | **2,009.4** | **1** | **45,422.2** | **1** | **2,009.4** | **1** | **45,422.2** | **1** | **45,422.2** |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл** *(мянган төгрөгөөр)*

| № | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Ажлаагүй үед цалин олгосон | 1 | 345.7 | 1 | 345.7 | | | | |
| 2 | Хоолны хөнгөлөлт илүү олгосон | 1 | 85.0 | 1 | 85.0 | | | | |
| 3 | Нийгмийн даатгал дутуу тайлагнасан | 1 | 4,776.2 | | | 1 | 4,776.2 | | |
| 4 | ХХОАТ буруу тайлагнасан | 1 | 1,124.0 | | | 1 | 1,124.0 | | |
| **Дүн** | | **4** | **6,330.9** | **2** | **430.7** | **2** | **5,900.2** | **-** | **-** |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** *(мянган төгрөгөөр)*

| № | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил** | | | | | | | |
| 1 | 4 мэдээллийг хугацаа хоцроож, 1 мэдээллийг огт оруулаагүй | 1 | - | 1 | - | | |
| | Дүн | 1 | - | 1 | - | - | - |